



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/44

Дэлгэрмөрөн

Г Засаг даргын нөөц хөрөнгөөс  
хөрөнгө зарцуулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2.1.3, 2.1.5 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумд хэрэгжиж буй орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих төслийн хөрөнгөөр 40 тоннын кантенор, тоног төхөөрөмжийг авах ажлыг тухайн сум өөрөө хариуцах учир тээврийн зардлыг шийдвэрлэсүгэй.

2.Тухайн тээврийн зардлын үнэ болох 1800000 (Нэг сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Р.Мөнхбилэг)-т зөвшөөрсүгэй.

3.Анхан шатны санхүүгийн баримтыг бүрдүүлж тайлан тооцоог гаргаж ажиллахыг Нярав (Ч.Бурмаа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.



ДАРГА

С.СУМЪЯАБАЗАР